



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 39

Мандалговь

Хөрөнгө үнэлж бүртгэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. 2016 оны орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогоор бүртгэлгүй байсан Хүнс, хөдөө аж ахуйн газрын баруун талд байрлах гүн өрмийн худгийг 10,000,000.0 /арван сая/ төгрөгөөр үнэлэн Хүнс, хөдөө аж ахуйн газрын баланст бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлд бүртгэж авахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүрэг гүйцэтгэгч Б.Мөнхжаргалд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР